



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар A/19

Эрдэнэт

**Цэрэг татлагын эмнэлгийн үзлэг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг, Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн "Цэрэг татлагын товчоо байгуулах, урьдчилсан үзлэг явуулах тухай" А/105 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны цэрэг татлагын эмнэлгийн үзлэг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Л.Амгаланбат (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Т.Болдбаатар (Сангийн далай багийн Засаг дарга)

Г.Билэгдэмбэрэл (Баяннуур багийн Засаг дарга)

Х.Даш-Очир (Баянзүрх багийн Засаг дарга)

Б.Одхүү (Нүхт багийн Засаг дарга)

Ц.Ичинхорлоо (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Б.Уранчимэг (Ерөнхий боловсролын сургуулийн насан туршийн

боловсролын багш)

Г.Баасанцэрэн (Хэсгийн төлөөлөгч)

Б.Баярсайхан (Эрүүл мэндийн төвийн дарга)

Ж.Лхамсүрэн (Соёлын төвийн дарга)

Ч.Чагдарсүрэн (Бүжгийн багш)

Л.Пүрэвжав (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Э.Хүрэлбаатар (Байгаль хамгаалагч)

Н.Бат-Эрдэнэ (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

С.Даваадорж (Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Н.Болормаа (Улсын бүртгэгч)

2.Ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж дүнг танилцуулахыг комисс (Л.Амгаланбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАТ-ЭРДЭНЭ



Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Засаг даргын
2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн
А/19 дугаар захирамжийн хавсралт



АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Д/д	Хийх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Зарлан дуудах хуудас бичих, тараах, өөрчлөлт хөдөлгөөн хийх	III/21- IV/14	Н.Болормаа, Л.Пүрэвжав, Багийн Засаг дарга нар
2	Сургалт мэдээллийн болон урлаг спортын арга хэмжээг зохион байгуулах	IV/15- IV/16	Комисс
3	Боловсролын төвшний судалгаа гаргах	IV/14	Б.Уранчимэг
4	Эрүүл мэндийн төвшинд дүн шинжилгээ хийж зохион байгуулсан ажлын тайлан бэлтгэх	IV/13	Б.Баярсайхан
5	Дүйцүүлэх алба хааж байгаа албан хаагчдын тайлан бичих	IV/13-аас өмнө	Н.Болормаа Л.Пүрэвжав
6	Шинээр 18 нас хүрсэн иргэдэд анкет нээж бичих	IV/14	Н.Болормаа Л.Пүрэвжав
7	Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах	IV/15	Б.Баярсайхан
8	Эмнэлгийн үзлэгийн байр бэлдэх	IV/16	Ж.Лхамсүрэн Б.Баярсайхан
9	Хувцас тайлах өрөө бэлтгэх, хяналт тавих	IV/16	Ч.Чагдарсүрэн С.Даваадорж
10	Анкет тараах	IV/16	Т.Болдбаатар Б.Одхүү
11	Өндөр жин хэмжих	IV/16	Г.Билэгдэмбэрэл Х.Даш-Очир
12	Үзлэгт бэлтгэх шаардлагатай багаж хэрэгслээр хангах	IV/16	Б.Баярсайхан
13	Эрүүл мэндийн даатгалд хамруулах	IV/15	Ц.Өлзийбадрах
14	Гэнэтийн ослын даатгалд хамруулах	IV/16	Э.Хүрэлбаатар
15	Тооцооны хуудас бичих	IV/16	Л.Пүрэвжав
16	Төлбөрийн тооцоо хийх	IV/16	Л.Амгаланбат Багийн Засаг дарга нар
17	Нийгмийн дэг журам сахиулах	IV/15- IV/16	Г.Баасанцэрэн
18	Тэнцсэн цэргийн үүрэгтнийг аймагт хүргэх	Тогтоосон хугацаанд	Л.Амгаланбат
19	Бичиг хэргийн үйлчилгээ үзүүлэх	IV/16	Ц.Ичинхорлоо